

26



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

᠑᠒᠔᠗᠗ оны ᠒᠒ сарын ᠒5 өдөр

Дугаар 8/10

Номгон

**Ковидын дараах сурлагын хоцрогдлыг нөхөх,
арилгах төлөвлөгөө батлах тухай**

Аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын теле хичээлд хамрагдалт 2020 оны 2-5 дугаар сард улсын дундаж 74,7 хувь, аймгийн дундаж 78 хувь, сумын дундаж 60 хувь байсан. НҮБ-ийн хүүхдийн сангаас 2021 онд авсан судалгаанд оролцогч 18133 хүүхдийн 8078 буюу 44.5 хувь нь теле хичээл үзээгүй байна

Техник, технологийн болон гэр бүлийн ялгаатай орчинд сурагчид зайнаас суралцах хэлбэрт шилжсэн нь тэгш бус байдлыг улам бүр нэмэгдүүлсэн.

Боловсролын үнэлгээний төвөөс сургуульд суурилсан үнэлгээг 2-12-р ангийн бүх сурагчдыг хамруулан, 18 судлагдахуун тус бүрээр оношилоход Математикийн хичээл (бага анги)-40.2%, дунд анги-32%, ахлах анги-31.3%, Монгол хэлний хичээл (бага анги)-50.2%, дунд анги-44.0%, ахлах анги-41.9% байна.

Иймээс Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын сурлагын хоцрогдлыг илрүүлэх, сурагчдын сурлагын түвшин тогтоох, арилгах аймгийн хэмжээний нэгдсэн бодлого төлөвлөлтийг боловсруулан ажиллах шаардлага үүсч байгааг ТЭМДЭГЛЭЭД:

Монгол Улсын Засаг, захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17, 48 дугаар зүйлийн 48.1, Боловсролын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит VIII хуралдаанаас ТОГТООХ нь:

1.“Ковидын дараах сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах төлөвлөгөө”-г төлөөлөгчдөөс гаргасан саналыг тусган хавсралтаар баталсугай.

2.Аймгийн Засаг дарга (Д.Мөнхсайхан)-д ДААЛГАХ нь:

2.1.Төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар ханган хяналт тавьж ажилласугай.

2.2.Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад шаардлагатай хөрөнгө санхүүгийн асуудлыг орон нутгийн төсөвт тусгаж батлуулсугай.

2.3.Төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнгийн талаарх мэдээллийг 2022 оны IV улиралд багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд танилцуулсугай.

0121106

3.Боловсролын хоцрогдлыг арилгахад сум орон нутаг тусгайлан анхаарч, орон нутгийн хөгжлийн сан, давсан орлого, сумын төсвөөс тодорхой хэсгийг гаргаж, төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллахад анхаарч ажиллахыг сумдын удирдлагуудад үүрэг болгосугай.

4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын үүргийн түр орлон гүйцэтгэгч (Т.Норов)-д үүрэг болгосугай.

5.Төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад, төсөв санхүүгийн хуваарилалтад хяналт тавьж үр дүнг тооцож ажиллахыг Нийгмийн бодлогын асуудал эрхэлсэн хороонд даалгасугай.


ДАРГА



Э.ЭНХБАТ



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн ээлжит
хуралдааны 8/10 дугаар тогтоолын хавсралт



КОВИДЫН ДАРААХ СУРАЛЦАГЧДЫН СУРЛАГЫН ХОЦРОГДЛЫГ НӨХӨХ, АРИЛГАХ 2022-2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төлөвлөгөө хэрэгжүүлэх үндэслэл: Боловсрол, шинжлэх ухааны сайдын “Төлөвлөгөө баталж хэрэгжүүлэх тухай” 2021 оны А/190 дүгээр тушаалаар баталсан “Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах төлөвлөгөө”-г хэрэгжүүлэхэд 2021 оны эхний хагас жилд сурагчдын теле хичээлд хамрагдалтын улсын дундаж 74,7%, аймгийн дундаж 78%, сумын дундаж 60% байсан.

1. 2021 онд НҮБ-ын “Хүүхдийн сан”-аас авсан судалгаанд 18133 хүүхэд оролцсоноос 4750 буюу 26.1 хувь нь ямар нэгэн шалтгаанаар теле хичээл үзээгүй байна.

2. Техник, технологийн болон гэр бүлийн ялгаатай орчинд сурагчид зайнаас суралцах хэлбэрт шилжсэн нь тэгш бус байдлыг улам бүр нэмэгдүүлсэн.

3. Сургуульд суурилсан үнэлгээг 2-12-р ангийн бүх сурагчдыг хамруулан, 18 судлагдахуун тус бүрээр оношлоход Математикийн хичээл /бага анги/- 40.2%, дунд анги-32%, ахлах анги-31.3%, Монгол хэлний хичээл /бага анги/ -50.2%, дунд анги-44.0%, ахлах анги-41.9% байна.

Иймд суралцагчдын сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах, суралцагчдын нийгэм, сэтгэл зүйн хэвийн байдлыг хангахад эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, сургалтын агуулга, сурлагын хоцрогдолд тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхийн тулд аймгийн хэмжээний нэгдсэн төлөвлөлтийг шинэчлэн боловсруулж, биелэлтийг ханган ажиллах шаардлага үүсэж байна.

Зорилго: Цар тахлын үеийн хөл хорионы улмаас үүссэн суралцагчдын сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах, тэдний суралцахуйг дэмжих үйл ажиллагааг удирдан зохион байгуулах

Зорилт:

1. Агуулгын хоцрогдлыг нөхөх, арилгах, эцэг эх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх.
2. Сургалтын цахим орчин, хэрэглэгдэхүүнийг сайжруулах, нэмэгдүүлэх
3. Суралцахуйг дэмжих үйл ажиллагааг нэмэгдүүлэх, багшлах арга зүйг сайжруулах
4. Тэгш хамруулах сургалтын үйл ажиллагааг дэмжих
5. Нотолгоонд суурилсан сайн туршлагаа хуваалцах, хамтран хөгжих боломжийг бүрдүүлэх

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт /хүрэх үр дүн/	Хариуцах эзэн, хамтран ажиллах байгууллага	Суурь түвшин	Хүрэх үр дүн		Санхүүгийн эх үүсвэр
				2022	2023	
1	2	3	4	5	6	7
ЗОРИЛТ 1: АГУУЛГЫН ХОЦРОГДЛЫГ НӨХӨХ АРИЛГАХ, ЭЦЭГ ЭХ, ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ						
Арга хэмжээ 1. КОВИД-19 цар тахлаас үүссэн сургууль завсардалтын талаар судалж, сургуулиас хөндийрсөн, сургууль завсардах эрсдэлтэй сурагчдыг сургуульд буцаан оруулах	Хөл хорионы үед сургууль, багштайгаа эргэн холбогдсон хүүхдийн эзлэх хувь	Сумын ЗДТГ, ЕБС НТБ-ын нэгж Эцэг эх, олон нийтийн оролцоо	Сургууль завсардах магадлалт ай 84 хүүхэд	90%	100%	Орон нутгийн төсөв 16.8 сая
Арга хэмжээ 2. Сурагч, эцэг эх, багш нарт сэтгэл зүйн зөвлөгөө өгч, дэмжин туслах, гэр бүлийн болон сэтгэл зүйн эерэг орчин бүрдүүлэх зорилгоор явуулын сэтгэл зүйч ажиллуулах	Сэтгэл зүйчтэй сургуулийн тоо Сэтгэл зүйн дэмжлэг үзүүлсэн үйлчилгээний тоо	Сумын ЗДТГ БШУГ ЕБС	Сэтгэл зүйчтэй сургууль 1	6 сургууль 15 үйлчилгээ	10 сургууль 15 үйлчилгээ	Орон нутгийн төсөв 10 сая
Арга хэмжээ 3. Сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгахад эцэг эхийн зөвлөл, сургуулийн зөвлөлийн хүлээх үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх, хамтран ажиллах	Хүүхдэд суралцахуйн дэмжлэг үзүүлэх чадвартай болсон эцэг эхийн тооны өсөлтийн хувь	ЕБС Эцэг эх	0%	25%	40%	
Арга хэмжээ 4. Сурлагын хоцрогдлыг оношлох	Судлагдахуун, сурагч нэг бүрээр	БҮТ БШУГ ЕБС	0	1 удаа	1 удаа	Улсын төсөв

1	2	3	4	5	6	7
Арга хэмжээ 5. Ковидын дараах сурагчдын агуулгын хоцрогдлыг нөхөх, арилгах ажил арга хэмжээ зохион байгуулж, үр дүнтэй ажилласан багшийг урамшуулах	Сургуульд суурилсан үнэлгээнд тулгуурлаж 2-12 ангийн сурагчдын гарааны үнэлгээг судлагдахуун бүрээр тогтоох	ЗДТГ БШУГ ЕБС	0	1 удаа	1 удаа	
	Сурлагын хоцрогдолтой байгаа сурагчдад танхимаар нэмэлт давтлага өгөх ажлыг ЕБС-ийн багш нар зохион байгуулах		60%-иас доош үнэлгээтэй сурагчид	Бүтэн жилээр	-	
	Сурлагын хоцрогдлыг суурь түвшнээс 20-с дээш хувиар ахиулсан багшийг шагнаж урамшуулах		0	100-200 багш	-	Орон нутгийн төсөв 100 сая
	Ахиц амжилтыг тооцох шалгалт зохион байгуулах		0	1 удаа	-	Орон нутгийн төсөв 30 сая
ЗОРИЛТ 2: СУРГАЛТЫН ЦАХИМ ОРЧИН, ХЭРЭГЛЭГДЭХҮҮНИЙГ САЙЖРУУЛАХ, НЭМЭГДҮҮЛЭХ						
Арга хэмжээ 1. Сургуулиудын интернэт сүлжээний холболтын найдвартай ажиллагааг хангаж, хурдыг нэмэгдүүлэх	Интернет холболтын хурд нэмэгдсэн байдал	БШУЯ	2МВ	3МВ	4МВ	Улсын төсөв
Арга хэмжээ 2. Багш нарыг зөөврийн компьютерээр хангах	Зөөврийн компьютертэй багшийн эзлэх хувь	БШУЯ ЗДТГ	5%	50%	50%	Улсын төсөв 1.415 тэрбум
Арга хэмжээ 3. Цахим контентын лаборатори байгуулах	17 сургуульд нийлүүлнэ.	БШУЯ	2 сургууль	5 сургууль	10 сургууль	Улсын төсөв 125 сая
Арга хэмжээ 4. Сурагчийг сургалтын таблетаар хангах	Нэг таблетэд ногдох сурагчийн тоо	БШУЯ	0	225 ш	-	650 сая Улсын төсөв
Арга хэмжээ 5. MEDLE.MN сайтад цахим контент байршуулах	Системд оруулсан цахим контентын тоо	БШУГ ЕБС	50 хичээл	169 контент, хичээл	200 контент, хичээл	Орон нутгийн төсөв 5 сая

1	2	3	4	5	6	7
Арга хэмжээ 6. Орон нутгийн хэмжээнд үнэлгээний даалгаврын сан бүрдүүлэх	Цахим систем дэх үнэлгээний даалгаврын тоо	БШУГ ЕБС	0	2000 даалгав ар	3000 даалгава р	Орон нутгийн төсөв 5 сая
Арга хэмжээ 7. Сурагчдын бие даан суралцах ажлын дэвтэр боловсруулж хэвлэх (бага), цахимд байршуулах (дунд, ахлах) • Бага анги: математик, монгол хэл, унших чадвар • Дунд анги: математик, монгол хэл байгалийн ухаан, нийгмийн ухааны нэгдмэл хичээл • Ахлах анги: математик, монгол хэл, байгалийн ухаан, нийгмийн ухааны сонгон судлах 3 хүртэлх хичээлээр	Бие даан суралцах ажлын дэвтэр хэвлэсэн хувь (бага анги)	БШУЯ БШУГ ЕБС	20%	70%	100%	Байгууллагын төсөв
	Бие даан суралцах ажлын дэвтэр хэрэглэсэн сурагчийн эзлэх хувь		40%	100%	100%	-
ЗОРИЛТ 3: СУРАЛЦАХУЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ НЭМЭГДҮҮЛЭХ, БАГШЛАХ АРГА ЗҮЙГ САЙЖРУУЛАХ						
Арга хэмжээ 1. Сурлагын хоцрогдол нөхөхөд сурагчдад дэмжлэг үзүүлэх зорилгоор дэмжигч багш ажиллуулах	Дэмжигч багшийн тоо	БШУГ ЕБС	0	40	40	Байгууллагын төсөв
Арга хэмжээ 2. Алслагдсан баг, тосгоны сурагчдын сурлагын хоцрогдол нөхөхөд дэмжлэг үзүүлэх зуны сургалт зохион байгуулах, явуулын багш ажиллуулах	Явуулын багш ажиллуулах сургуулийн тоо	БШУГ Сумын ЗДТГ ЕБС	0	30 сургууль	30 Сургууль	Орон нутгийн төсөв 60 сая
Арга хэмжээ 3. Сум, багийн сургууль, олон хүүхэдтэй ажиллаж буй багш нарт сурагчдын сурлагын хоцрогдол нөхөхөд дэмжлэг үзүүлэх зорилгоор дадлагын багшийг ажиллуулах	Дадлагажигч багшийн тоо	БШУГ ЕБС	0	60	60	Орон нутгийн төсөв 60 сая
Арга хэмжээ 4. Дотуур байртай сургууль бүр сурагчийн сурлагын хоцрогдлыг нөхөх төлөвлөгөө боловсруулж ажиллах, дотуур байрын багш нарын сургалтыг дэмжих тогтолцоонд татан оролцуулах	Дэмжих тогтолцоонд татан оруулсан дотуур байрын багшийн тоо	БШУГ ЕБС	-	24	24	
Арга хэмжээ 5: Цахим контент боловсруулах арга зүйг хөгжүүлэх сургалт зохион байгуулж, багш нарыг чадваржуулах	-сургалтад хамрагдсан багшийн эзлэх хувь -чадваржсан багшийн эзлэх хувь	БШУГ ЕБС	30%	60%	80%	Орон нутгийн төсөв 40 сая

1	2	3	4	5	6	7
Арга хэмжээ 6: “Баянхонгор-боловсрол” цахим сургалтын платформ нэвтрүүлэх	-Цахим сургалтын платформ нэвтрүүлсэн сургуулийн тоо	БШУГ ЕБС	0	60%	100%	Орон нутгийн төсөв 10 сая
ЗОРИЛТ 4. ТЭГШ ХАМРУУЛАХ СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ						
Арга хэмжээ 1. Хөгжлийн бэрхшээлээс үүссэн хоцрогдлыг нөхөх, арилгах ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх	Ганцаарчилсан төлөвлөгөөгөөр хичээллэх хүүхдийн эзлэх хувь	БШУГ НТБ-ын төв ЕБС ХБХ-н боловсрол эрүүл мэнд нийгмийн хамгааллын салбар комисс	26,5%	30%	35%	Байгууллагын төсөв
Арга хэмжээ 2. Сургуулиас завсардсан, огт сургуульд хамрагдаагүй зорилтот бүлгийн хүүхдэд боловсрол нөхөн олгох хөтөлбөрөөр хоцрогдол арилгах сургалт зохион байгуулах	Сургалтад хамрагдсан хүүхдийн тоо	БШУГ НТБТөв ЕБС	38	48	58	
Арга хэмжээ 3. Ерөнхий боловсролын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн суралцах таатай орчныг бүрдүүлэх, тэдэнд зориулсан сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмж бүхий “Хүүхэд хөгжлийн танхим” байгуулах	Сургалтын орчин бүрдүүлсэн сургуулийн тоо 10	БШУГ ЕБС	5	2	3	Олон улсын байгууллагын зээл тусламж 25 сая
Арга хэмжээ 4. Хүнд болон хэвтрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг бичиг үсэгт тайлах, бага, суурь боловсрол олгох явуулын багш ажиллуулах	Гэрээр сургалтад хамрагдсан хүүхдийн хувь	БШУГ ЕБС	2%	5%	5%	Байгууллагын төсөв
	Гэрээр ажилласан багшийн тоо	БШУГ ЕБС	5	13	26	Байгууллагын төсөв
ЗОРИЛТ 5: НОТОЛГООНД СУУРИЛСАН САЙН ТУРШЛАГАА ХУВААЛЦАХ, ХАМТРАН ХӨГЖИХ БОЛОМЖИЙГ БҮРДҮҮЛЭХ						
Арга хэмжээ 1. Хичээлүүдэд интеграци хийж, нэгдмэл хичээлийн арга зүйг туршсан үр дүн болон хоцрогдлыг нөхөж арилгаж буй сайн үр дүн, туршлагыг сургууль, аймгийн түвшинд түгээн дэлгэрүүлэх	Цахим санд байршуулсан сайн туршлагын тоо	БШУЯ БШУГ ЕБС	50 хичээл	169 контент, хичээл	200 контент, хичээл	

1	2	3	4	5	6	7
Арга хэмжээ 2. Сурлагын хоцрогдол нөхөх, арилгах сайн туршлагыг цахим санд байршуулж, сургалтын үйл ажиллагаанд ашиглах	Сайн туршлагыг сургалтдаа хэрэгжүүлсэн сургуулийн эзлэх хувь	БШУЯ БШУГ ЕБС	30%	80%	100%	
Арга хэмжээ 3. Мэргэжлийн бүлгээр орон нутгийн багш нарын тасралтгүй хөгжлийг хангах үйл ажиллагааг төлөвлөж хэрэгжүүлэх	Тасралтгүй үйл ажиллагаатай болсон мэргэжлийн бүлгийн тоо	БШУЯ БШУГ ЕБС	16	20	25	
Арга хэмжээ 4. Сурлагын хоцрогдолд нөлөөлж буй хүчин зүйлд судалгаа хийх	Судалгаа	БШУЯ БШУГ ЕБС	0	1 удаа	-	
Арга хэмжээ 5. Сургуульд суурилсан менежмент, сургуулийн өөрийн үнэлгээг нэвтрүүлэх	Өөрийн үнэлгээний тогтолцоог хэрэгжүүлсэн сургуулийн эзлэх хувь	БШУЯ БШУГ ЕБС	-	40%	60%	
Арга хэмжээ 7. Сурлагын хоцрогдол нөхөх, арилгах, орон нутгийн санхүүжилтийг нэмэгдүүлэх	Аймаг, сум хөгжүүлэх сангийн төсөвт боловсрол нөхөн олгох үйл ажиллагааны зардлын эзлэх хувь	БШУЯ БШУГ ЕБС	0%	10%	10%	
Хяналт-шинжилгээ үнэлгээний ерөнхий шалгуур						
Зорилго	Шалгуур үзүүлэлт (хүрэх үр дүн)	Хариуцах эзэн	Суурь түвшин	Зорилтот түвшин (өссөн түвшингээр)		
				2022	2023	
Цар тахлын үеийн хөл хорионы улмаас бий болсон сурагчдын сурлагын хоцрогдол нөхөх, арилгах, тэдний суралцахуйг дэмжих үйл ажиллагааны үр дүн, үр ашиг, үр нөлөөг үнэлэх	R1. Хөл хорионы дараа сургуульдаа эргэн суралцсан хүүхдийн эзлэх хувь	БШУГ ЕБС	-	98%	100%	Байгууллагын төсөв
	R2. Дэмжих сургалтад хамрагдах шаардлагатай сурагчдын хоцрогдол нөхөх сургалтад хамрагдсан хувь	БШУГ ЕБС	0	90%	100%	

1	2	3	4	5	6	7
	R2. Дэмжигч багшийн хоцрогдол нөхөх үйл ажиллагааны гүйцэтгэлийн хувь	БШУГ ЕБС	0	90%	100%	
Цар тахлын үеийн хөл хорионы улмаас бий болсон сурагчдын сурлагын хоцрогдол нөхөх, арилгах, тэдний суралцахуйг дэмжих үйл ажиллагааны үр дүн, үр ашиг, үр нөлөөг үнэлэх	R2. Хосолсон сургалтын орчин бүрдүүлсэн сургуулийн эзлэх хувь	БШУГ ЕБС	0	80%	100%	
	R1-3. Агуулгын хоцрогдол нөхсөн сурагчдын эзлэх хувь	БШУГ ЕБС	-	80%	90%	
	R1-3. Сурагчийн сурлагын амжилтын өсөлтийн хувь	БШУГ ЕБС	-	10%	10%	
	R1-3. Өөрийн үнэлгээнд суурилсан бие даан хэрэгжүүлдэг болсон сургуулийн эзлэх хувь	БШУГ ЕБС	0	80%	100%	
НИЙТ ТӨСӨВ				Орон нутгийн төсөв		336.800.000
				Улсын төсөв		2.190.000.000
				Төсөл хөтөлбөр		25.000.000
				Байгууллагын төсөв		
				Дүн		2.551.800.000

ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХАМТЫН АЖИЛЛАГАА

Сургуулийн өмнөх боловсрол, Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын сурлагын хоцрогдол нөхөх, арилгах төлөвлөгөө нь сургууль, цэцэрлэгийн түвшинд өөрийн удирдлагатай суралцахуйг дэмжих, орон нутгийн түвшинд хосолсон сургалтын орчин арга зүйг дэмжих бодлого, арга зүй, санхүү менежментээр дэмжихэд чиглэж, удирдлага зохион байгуулалтыг Боловсролын газар хариуцан хэрэгжүүлэх бөгөөд талуудын оролцоог хангаж, үр дүнг тооцон ажиллана.

➤ **Дэмжих тогтолцоог хэрэгжүүлэх талуудын оролцоо:**

1. Аймаг, сумын ИТХ
2. Аймаг, сумын Засаг даргын Тамгын газар
3. Боловсрол шинжлэх ухааны газар
4. Насан туршийн боловсролын төв
5. Төрийн болон төрийн бус өмчийн ЕБС, цэцэрлэг
6. Багш нар
7. Суралцагчид

➤ **Дэмжих тогтолцоог хэрэгжүүлэх олон нийтийн оролцоо:**

1. Албан байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага

2. Орон нутгийн хөгжлийн түншлэгч байгууллага

3. Сургалтын төвүүд /Сургууль, багш, эцэг эхтэй харилцан тохиролцож, сурагчдын оношилгооны үр дүн, сурагчийн өөрийн төлөвлөгөөнд үндэслэн, сурлагын хоцрогдлыг арилгах чиглэлээр хамтран ажиллаж, сурагчдын ахиц, амжилт, хөндлөнгийн үнэлгээгээр үнэлсэн үр дүнг тооцох/

4. Эцэг эхийн зөвлөл /Сургуулийн зөвлөлөөр дамжуулан сургууль багш нартай хамтран ажиллах, шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагуудтай хамтран хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явцад оролцох/